



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Төслийн удирдах хороо байгуулах,
журам батлах тухай

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газар ба Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газар хоорондын 2011 оны 12 дугаар сард байгуулсан "Зүрх судасны төв, эх нярайн эрүүл мэнд ба цахим эрүүл мэндийн өргөжил" МОН/005 төслийг хэрэгжүүлэх буцалтгүй тусламжийн харилцан ойлголцлын санамж бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Зүрх судасны төв, эх нярайн эрүүл мэнд ба цахим эрүүл мэндийн өргөжил" төслийн Удирдах хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, удирдах хорооны ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Удирдах хорооны үйл ажиллагааг холбогдох дүрэм журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Удирдах хорооны дарга /С.Ламбаа/-д даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 137 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080061

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 01 сарын 18 өдрийн
18 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

ЗҮРХ СУДАСНЫ ТӨВ, ЭХ НЯРАЙН ЭРҮҮЛ МЭНД БА ЦАХИМ ЭРҮҮЛ МЭНДИЙН
ӨРГӨЖИЛТ” МОН/005 ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: Эрүүл Мэнд, Спортын Яамны Төрийн Нарийн Бичгийн Дарга
- Дэд дарга: Люксембургийн Их Гүнт Улсын Гадаад Хэргийн Яамны төлөөлөл
- Нарийн бичгийн дарга: Зүрх судасны төв, Эх нярайн эрүүл мэнд ба Цахим эрүүл мэндийн өргөжилт МОН/005 төслийн Үндэсний Зохицуулагч
- Гишүүд:
- ЭМСЯ-ны, Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга
 - ЭМСЯ-ны, Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
 - ЭМСЯ-ны, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
 - Сангийн Яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга /зөвшилцсөнөөр/
 - Люксембургийн хөгжлийн хамтын ажиллагааны агентлагийн төлөөлөл /зөвшилцсөнөөр/
 - НҮБ-ын Хүн Амын Сангийн суурин төлөөлөгч /зөвшилцсөнөөр/
 - П.Н.Шастины нэрэмжит Улсын III Төв Эмнэлгийн дарга /зөвшилцсөнөөр/
 - Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн дарга /зөвшилцсөнөөр/

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 07 сарын 18 өдрийн
18 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

"ЗҮРХ СУДАСНЫ ТӨВ, ЭХ НЯРАЙН ЭРҮҮЛ МЭНД БА ЦАХИМ ЭРҮҮЛ
МЭНДИЙН ӨРГӨЖИЛ" МОН/005 ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ
АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Зорилго

- 1.1 Төслийн үйл ажиллагааг стратегийн нэгдсэн удирдлагаар хангах
- 1.2 Төслийн үйл ажиллагааг үндэсний бодлого, стратегийн хүрээнд уялдуулан зохицуулах

Хоёр. Удирдах хорооны чиг үүрэг

- 2.1 Төслийн баримт бичигт оруулах томоохон өөрчлөлтүүдийг хянан батлах
- 2.2 Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн төслийг хянан, баталгаажуулах
- 2.3 Төслийн жилийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэн дүгнэх
- 2.4 Төслийн үйл ажиллагааг бусад үндэсний болон олон улсын хөтөлбөр төслүүдтэй уялдуулан зохицуулах
- 2.5 Бусад яаралтай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэх

Гурав. Үйл ажиллагаа

- 3.1 Удирдах хороо нь жилд нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурал зохион байгуулж болно.
- 3.2 Хорооны дарга, дэд дарга нар Эрүүл мэнд, спортын сайд болон бусад холбогдох албан тушаалтан, байгууллагад төслийн хэрэгжилтийн талаар тайлагнана.
- 3.3 Хорооны гишүүдийн 70-аас дээш хувь биечлэн оролцсоноор хурлын ирц бүрэлдсэнд тооцож, хурлыг нээнэ.
- 3.4 Хуралд оролцож байгаа гишүүдийн олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно. Гишүүд санал тэнцсэн тохиолдолд даргын саналаар асуудлыг шийлвэрлэнэ.
- 3.5 Нарийн бичгийн дарга нь хорооны хурлын товыг Удирдах хорооны даргатай зөвшилцөж, хурал болохоос ажлын 5 хоногийн өмнө зарлах, хурлын тэмдэгт хатгах, хурлын тэмдэглэл, хурлаас гарсан зөвлөмжүүлийг эцэслэн гишүүдэд түгээх үүрэг хүлээнэ.
- 3.6 Удирдах хорооны даргын зөвшөөрлөөр бусад олон улсын байгууллага, хандивлагч байгууллагууд болон мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг ажиглагчаар урин оролцуулж болно.